

2008.04.18

Дугаар 97

“Их арвижих үйлс” ХХК-д валют солих цэгийн  
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 200 дугаар тогтоолоор баталсан “Валют солих цэгийн үйл ажиллагааны зохицуулалтын түр журам”-ын 5.4 дэх хэсгийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.”Их арвижих үйлс” ХХК-д валют солих цэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2.Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Их арвижих үйлс” ХХК /Н.Энхцэцэг/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ